



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Нийцлийн аудитын тайлан

*ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад
тавих иргэдийн болон иргэний
нийгмийн байгууллагуудын
хөндлөнгийн хяналт сул байснаас
зориулалтын дагуу зарцуулагдаагүй
байна.*

2015 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймгийн Аудитын газар Аймгийн Тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо Аудитын менежер Д.Оюунбат Ахлах аудитор Ц.Батсайхан Аудитор Г.Наранбаяр Шинжээч Э.Гансүх Шинжээч Э.Цэлмэгбаяр 2015 оны 05 дугаар сар	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 Бүлэг 1. Аймгийн ОНХС-гийн санхүүжилт болон үндсэн тэнцлийн ашгийг дутуу төвлөрүүлсэн байна. 1.1 Аймгийн Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д олгох шилжүүлэг төлөвлөсөн хэмжээнээс хасагдаж олгогдсон байна. 1.2 Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.1-д заасан Тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний дагуу улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг орон нутгийн суурь зарлага болон бусад санхүүжилтэд зарцуулаагүй байна. 1.3 Аймгийн ОНХС-д төвлөрүүлэх 2013 оны үндсэн тэнцлийн ашгаас 33,833.7 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Бүлэг 2: ОНХС-гийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу зарцуулаагүйгээс 2,362,021.7 мянган төгрөгийн зөрчил, дутагдал гаргасан байна. 2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан хэдий ч иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй 33 төсөл арга хэмжээ буюу 802,380.6 мянган төгрөгийн ажлыг санхүүжүүлсэн байна. 2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ, зураг төсвийг өмнөх оны ОНХС-ийн төсөвт тусган баталж, хийлгэсэн ба зарцуулах хөрөнгө, төсөвт өртгийг урьдчилан тооцсон байна 2.3. ОНХС-гаас иргэдийн санал аваагүй, багийн ИНХ-аас дэмжигдээгүй 725,380.6 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг баталж, гүйцэтгүүлсэн байна. 2.4. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг ИТХ-аас батлахдаа их засварын ажлыг жагсаалт гаргалгүйгээр бөөн дүнгээр баталсан байна. 2.5. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна. 2.6. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн 502,496.6 мянган төгрөгийн хөрөнгийг данс, бүртгэлд дутуу тусгасан байна. Бүлэг 3: ОНХС-гийн хөрөнгийг зарцуулалтанд тавих шат шатны хяналтыг хангалттай зохион байгуулж ажиллаагүй байна.
---	--

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151 дугаарын утас, 7054-3179 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	3.1 ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийг иргэдэд ил тод мэдээлж ажиллаагүйгээс, сумдын иргэдийн оролцоо идэвх сул байна. 3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга, хэмжээний хэрэгжилтэд аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас хяналт тавьж ажилласан байна. 3.3 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хууль, журмын дагуу хүлээж авсан байна. 3.4 Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг 50 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна. 3.5 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Дүгнэлт..... Зөвлөмж..... Холбогдох байгууллагын санал: Саналд өгсөн тайлбар..... Хавсралтууд
--	--

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ГСА	Говьсүмбэр аймаг
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ТӨБОНӨХБАҮХАТХ	Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УБХ	Улсын бүртгэлийн хэлтэс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилт: Аймаг сумдын ОНХС-гийн 2014 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулан дүнг ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт хүргүүлэх, АИТХ, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ: Аудитыг аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн 2014 оны санхүүгийн тайлан, анхан шатны баримтууд, холбогдох бусад баримт материалд үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй: Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, харьцуулан шинжлэх, түүвэрчлэн шалгах, гүйцэтгэсэн ажлыг газар дээр нь очиж үзэн тулган баталгаажуулах зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Үндсэн мэдээлэл:

2014 онд Аймгийн хэмжээнд ОНХНС-гаас 7,911,179.9 мянган төгрөгийн орлогыг шилжүүлэгээр, 8,211.6 мянган төгрөгийг татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар, 50,000.0 мянган төгрөгийг үндсэн тэцлийн ашгаас бүрдүүлэхээр төлөвлөж, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлын дээд хэмжээг аймагт 3,172,693.6 мянга, Сүмбэр суманд 2,159,339.6 мянга, Баянтал суманд 1,330,691.7 мянга, Шивээговь суманд 1,306,676.6 мянга нийт 7,969,401.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Улсын төсвийн орлого тасарсан шалтгаанаар төсөвт 2 удаа тодотгол хийж, ОНХНС-гаас шилжүүлгийн орлогоос 582,419.8 мянган төгрөг хасагдаж, ноосны урамшуулал 6,448.5 мянга, үндсэн тэнцлийн ашгийг 631,001.1 мянга, халамж сангийн үлдэгдэл 62,362.0 мянга нийт 699,811.6 мянган төгрөгийг нэмж тодотгон ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлын дээд хэмжээг аймагт 4,126,409.0 мянга, Сүмбэр суманд

1,961,939.5 мянга, Баянтал суманд 882,189.2 мянга, Шивээговь суманд 1,116,255.6 мянга нийт 8,086. 793.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хийсэн нийцлийн аудитаар нийт 2,362,021.7 мянган төгрөгийн 104 зөрчил дутагдал илрүүлсэн ба 8,085.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 735.560.4 мянган төгрөгийн албан шаардлага, 1,207,815.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмж өгч, зарим холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэхээр тус тус төлөвлөөд байна.

Бүлэг 1

Аймгийн ОНХС-гийн санхүүжилт болон үндсэн
тэнцлийн ашгийг дутуу төвлөрүүлсэн байна.

1.1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д олгох шилжүүлэг төлөвлөсөн хэмжээнээс хасагдаж олгогдсон байна.

2014 онд Говьсүмбэр аймагт улсын төсвөөс 323,300.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөсөн бөгөөд дэмжлэгийг бүрэн олгосон байна.

Аймгийн ОНХС-гаас сумдын ОНХС-д олгох санхүүжилтийг Төсвийн тухай хуулийн дагуу тооцож 4,746,708.0 мянган төгрөгийг шилжүүлэхээр төлөвлөсөн боловч ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох санхүүжилтийг дутуу олгосноос шалтгаалан сумдад 874,974.2 мянган төгрөгийг дутуу олгосон байна. Үүнд: Сүмбэр суманд 371,977.6 мянга, Баянтал суманд 242,668.8 мянга, Шивээговь суманд 260,327.8 мянган төгрөгийг тус тус дутуу олгосон байна.

1.2. Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4.1-д заасан Тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний дагуу улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг орон нутгийн суурь зарлага болон бусад санхүүжилтэд зарцуулаагүй байна.

2014 онд ОНХНС-гаас 7,911,179.9 мянган төгрөгийн орлогыг шилжүүлгээр хүлээн авч зарцуулахаар батлагдсан бөгөөд Төсвийн тухай хуулийн 59.2 дахь заалтын дагуу сумдын орон нутгийн хөгжлийн санд орлогын 60 хувь буюу боловч УИХ-аас улсын төсвийн тодотгол хийхдээ тус аймгийн хэмжээгээр 582,419.8 мянган төгрөг хасагдаж, 7,328,760.1 мянган төгрөг батлагдсан тул сумдын ОНХС-ийн шилжүүлэгийн орлого хасагдсан байна.

1.3. Аймгийн ОНХС-д төвлөрүүлэх 2013 оны үндсэн тэнцлийн ашгаас 33,833.7 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

2014 онд ОНХСанд 2013 оны үндсэн тэнцлийн ашиг 689,222.7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 33,833.7 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна. Мөн сумдад улсын төсвөөс ноосны урамшуулалд олгосон 6,448.5 мянга, Сүмбэр сум халамжийн

сангийн үлдэгдэл 62,362.0 мянга, нийт 68,810.5 мянган төгрөгийн орлогыг аймгийн ОНХС-д төвлөрүүлэлгүйгээр сумын ОНХС-даа төвлөрүүлэн, зарцуулжээ. ОНХС-д дутуу төвлөрүүлсэн 33,833.7 мянга, халамжийн сангийн үлдэгдэл 62,362.0 мянга, 96,195.7 мянган төгрөгийг аймгийн ОНХС-д төвлөрүүлэхээр аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тавьсан байна.

Аймгийн ОНХС-ийн төлөвлөгөөнд Татварын орлогоор нийт 3,824,100.0 мянган төгрөг, үүнээс татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар 8,221.6 мянган төгрөгийн татварын нэмэлт орлого оруулахаар тус тус төлөвлөж, гүйцэтгэлээр 4,179,600.0 мянган төгрөг оруулж, татварын орлогын төлөвлөгөөг 109.0 хувиар давуулан байна.

2014 онд сумдын үндсэн тэнцлийн ашгаас 50,000.0 сая төгрөгийг аймгийн ОНХС-д төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 114,599.6 мянган төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 229.9 хувиар давуулан биелүүлсэн байна. Үүнд: Сүмбэр сум 75,151.4, Шивээговь сум 28,927.8 мянга, Баянтал 10,520.4 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

2014 оны ОНХС-гийн төлөвлөгөөнд төсвийн хэмнэлтээс төвлөрүүлэх орлого тусгагдаагүй, харин аймгийн ИТХ-ийн 2014 оны 7 сарын 28-ний 03 тоот тогтоолоор тус хэмнэлтийн орлого 82,424.4 мянган төгрөгийг тодотгож баталсан байна.

Аймгийн ОНХС-д хандив тусламжаар орлого төвлөрүүлэхээр тусгагдаагүй байна. Харин 2014 онд ҮХААЯ-наас сумдад олгосон ноосны урамшуулал 6,448.5 мянган төгрөг, Сүмбэр сум нь халамжийн сангийн санхүүжилтийн үлдэгдэл 62,362.0 мянган төгрөгийг ОНХС-д тус тус төвлөрүүлэн зарцуулсан байна.

Бүлэг 2

ОНХС-гийн хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу
зарцуулаагүйгээс 2.408.935.4 мянган төгрөгийн зөрчил,
дутагдал гаргасан байна.

2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдуулсан хэдий ч иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй 33 төсөл арга хэмжээ буюу 802,380.6 мянган төгрөгийн ажлыг санхүүжүүлсэн байна.

Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс нь ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөл арга хэмжээг 7 багц болгон иргэдээс санал авч багийн ИНХ-аар хэлэлцүүлж, аймаг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулж баталсан байна.

Гэвч Иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн Боржигин чуулгын дээвэр, цахилгааны монтажийн засварын ажлыг төсөв батлахдаа хасаж, иргэдийн авсан саналд эрэмбэлэгдээгүй 3 төрлийн 66,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил, 11,000.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч бэлтгэх ажил, нийт 77,000.0 мянган төгрөгийн ажлуудыг нэмж баталсан байна.

Мөн төсвийн тодотголоор иргэдийн санал авсан Аймгийн ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах ажлыг хасаж, Боржигин чуулгын дээвэр, цахилгааны монтажийн засварын ажлыг дахин нэмж оруулсан байна.

Сүмбэр, Баянтал сумууд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг багийн иргэдээс санал авч багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж эрэмбэлсэн бөгөөд иргэдийн саналын хуудас, багийн ИТХ-ын тэмдэглэл, эрэмбэлсэн жагсаалтыг үдэж архивласан байна.

Харин Шивээговь сум иргэдээ бүрэн хамруулж саналыг нь авсан боловч саналаа нэгтгэн жагсаалт гарган, эрэмбэлэхгүйгээр багийн ИНХ-аар хэлэлцүүлж ИТХ-аар батлуулсан байна.

2.2. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ, зураг төсвийг өмнөх оны ОНХС-ийн төсөвт тусган баталж, хийлгэсэн ба зарцуулах хөрөнгө, төсөвт өртгийг урьдчилан тооцсон байна.

Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс болон сумд нь ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ, зураг төсвийг өмнөх оны ОНХС-гийн төсөвт тусгуулан батлуулж, тайлант онд хийгдэх ажилд зарцуулагдах хөрөнгө, төсөвт өртгийг урьдчилан тооцсон байна. Үүнд: аймгийн төвийн ОНХС-аас хийгдэх ажлын ТЭЗҮ, зураг төсвийн өртөг 2013 онд 249,718.0 мянга, 2014 онд 200,000.0 мянган төгрөг тус тус баталсан байна.

2014 онд батлагдсан хөрөнгийн 57,500.0 мянган төгрөг нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах эмнэлэг, сургуулийн барилгын зураг төсөв, 142,500.0 мянган төгрөг нь их засварын ажлын зураг төсөв байна.

2.3. ОНХС-гаас иргэдийн санал аваагүй, багийн ИНХ-аас дэмжигдээгүй 802,380.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг баталж, гүйцэтгүүлсэн байна.

ОНХС-гаас багийн ИНХ-аар дэмжигдээгүй, иргэдийн санал аваагүй аймгийн төвд 4 төрлийн 77,000.0 мянга, Шивээговь суманд 2 төрлийн 36,586.6 мянга, Баянтал суманд 12 төрлийн 206,764.1 мянга, нийт 18 төрлийн 320,350.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг баталж, гүйцэтгүүлсэн байна.

Мөн аймгийн ИТХ төсвийн тодотгол хийхдээ ОНХС-гийн хөрөнгөөр хийх иргэдийн санал аваагүй, багийн ИНХ-аар дэмжигдэж, эрэмбэлэгдээгүй аймгийн төвд 9 төрлийн 414,430.0 мянга, Сүмбэр суманд 5 төрлийн 67,599.9 мянган төгрөгийн, нийт 14 төрлийн 482,029.9 мянган төгрөгийн ажлыг нэмж тодотгосон байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д зааснаар “Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”-нд зарцуулахыг хориглоно гэсэн заалтыг зөрчиж байна.

2.4. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг ИТХ-аас батлахдаа их засварын ажлыг жагсаалт гаргалгүйгээр бөөн дүнгээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх Нийтийн эзэмшлийн зам талбайн засвар, тохижилт, ногоон

байгууламжийг нэмэгдүүлэх ажил, нийтийн эзэмшлийн орон сууцнуудын засварын ажлуудыг тогтоолд багц дүнгээр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2014.03.26-ны өдрийн А/85 тоот захирамжийн хавсралтаар дээрх Нийтийн эзэмшлийн зам талбайн засвар, тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх багц ажлуудыг 5 ажил болгон задалж, баталсан боловч нийтийн эзэмшлийн орон сууцнуудын засварын ажлуудыг задалж батлаагүй байна.

Сүмбэр сумын ИТХ-аас баталсан ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын жагсаалтыг 2013 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 06 дугаар тогтоолоор баталж, ОНХС-гийн 2014 онд нийт 21 ажилд зарцуулах хөрөнгийн дээд хэмжээг 2,159,339.6 мянган төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс дараах 3 ажлыг сумын Засаг даргын захирамжаар 21 ажил болгон хуваасныг сумын ИТХ-ын 2014 оны 09 дүгээр сарын 05-ны 06 дугаар тогтоолоор төсвийн тодотгол хийж, өмнөх хуралдааны тогтоолоор баталсан жагсаалтад 18 ажил нэмж өөрчилсөн байна. Үүнээс:

- Иргэний танхим байгуулах, унаажуулахад 140,000.0 мянга,
- Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 100,000.0 мянга,
- Сумын хогны менежментийг сайжруулахад 180,000.0 мянган төгрөгийг ажлуудыг 3 багцлан сумын ИТХ-аар 21 ажил болгон батласан байна.

Энэ нь ТӨБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.5 –д “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэснийг зөрчин, нээлттэй тендер шалгаруулахаас зайлсхийж, 420,000.0 мянган төгрөгийн 21 ажлыг харьцуулалтын болон шууд гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн зарцуулалтад дараахь нийтлэг зөрчил дутагдлууд байна. Үүнд:

- Улсын баяр наадмыг зохион байгуулах зардалд МУЗГ-ын 2010 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” журмын 1 дүгээр зүйлд “Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай” гэснийг зөрчиж, аймагт 35,500.0 мянга, сумдад тус бүр 10,000.0 мянган төгрөгийг төлөвлөж, нийт 39,410.4 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсныг 2014 санхүүгийн аудитаар илрүүлэн албан шаардлага өгсөн байна.

- Сумдад ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг батлахдаа иргэний танхим байгуулах, унаажуулах нэрээр иргэдээс санал авч иргэдийн саналаар дэмжүүлж жагсаалтанд эрэмбэлүүлж, Сүмбэр сум 87,300.0 мянга, Шивээговь сум 58,850.0 мянга, Баянтал сум 80,000.0 мянга нийт 226.150.0 мянган төгрөгөөр сумдын Засаг дарга нарт суудлын автомашин худалдан авч сумын ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгүүлсэн нь ОНХС-гийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан тул сумдын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах саналыг холбогдох дээд байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Дээрх нийтлэг зөрчлөөс гадна аймаг, сумдын ОНХС-ийн зарцуулалтанд илэрсэн зөрчил дутагдлууд: Үүнд:

1. Аймгийн төвийн Орон нутгийн хөгжил сан: Тус сангийн хөрөнгөөр улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудад хөрөнгө бэлтгэж зориулалтын бус зүйлд зарцуулсан байна. Тухайлбал:

- Аймгийн Цагдаагийн хэлтэст хурд, согтуурал хэмжих багаж 10,978.0 мянга, ҮХААГ-т дунд оврын трактор, иж бүрдлийн хамт 45,000.0 мянга,
- Аймгийн Онцгой байдлын хэлтэст тоноглогдсон тусгай зориулалтын авто машин 197,850.0 мянга,
- УБХ-т тоног төхөөрөмж 4,000.0 мянга,
- Аймгийн ЗДТГ-т автомашин 145,000.0 мянга, нийт 402,828.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2013 оны Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний төв зогсоол байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Магнус солус” ХХК шалгарч 2013 онд 47,362.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, ажлаа гэрээний хугацаанд хийж гүйцэтгээгүй, хүйтний улирал эхэлсэнтэй холбоотой акт үйлдэн ажлыг зогсоож, 2014.04.10-наас 2014.05.20 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр гэрээг сунгасан байна.

Гэтэл 2014 онд уг компани ажлаа хийж гүйцэтгэлгүй алга болсон тул олгосон санхүүжилт 47,362.8 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгасанд байна. Иймд уг авлага болон гэрээний дагуу холбогдох алдангийг тооцож барагдуулах талаар албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

2. Сүмбэр сумын орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад илэрсэн зөрчил:

- Айл өрх, гудамж талбайн хаягжуулалт хийх ажлын хүрээнд 10,000.0 мянган төгрөг төсөвлөсөн бөгөөд сумын Засаг даргын захирамжаар уг ажлыг 3 хувааж Говьсүмбэр аймгийн газар нутгийн нэрийн зураг болон Сүмбэр сумын 1, 2, 3 дугаар багийн нэрийн зураг 13 ширхэг хэвлэхэд 2000.0 мянган төгрөг төлөвлөн “Сион Уул” ХХК-иар 10 ш газрын зураг 1,283.8 мянга, самбар 86.0 мянга, зураг 35.0 мянга, хулдаасан хэвлэл 70.2 мянга, товгор үсэг 128.0 мянга, төрийн сүлд 72.0 мянга, 5 хөшиг 325.0 мянган төгрөгөөр тус тус хийлгүүлж нийт 2,000.0 мянган төгрөгийг нэхэмжлэхийн дагуу шилжүүлсэн байна. Төрийн сүлд, товгор үсэг, хөшгийг иргэний танхимд байрлуулсан бөгөөд дээрх компанитай гэрээ байгуулаагүй, мөн иргэний танхим тохижуулах зардал уг ажлын төлөвлөгөөнд ороогүй учир зориулалт бүсаар зарцуулсан гэж үзэн нийт 525.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт бичсэн.
- Гамшгаас хамгаалах команд, штабын сургалтыг зохион байгуулахад 3,000.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд ажлын тайлан байхгүй байна. Мөн Сумын ЗДТГ-ын автомашины сэлбэгэнд 125.0 мянган төгрөг, хоолны зардалд 905.0 мянган төгрөг зарцуулсан байна. Цаашид байгууллагын урсгал зардал санхүүжүүлэхгүй байх талаар зөвлөмж өглөө.
- Соёл урлаг, биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд 18,235.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд үүнээс Сүмбэр сумын Засаг даргын 2014 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/107 дугаар захирамжаар Сүмбэр сумын 5 дугаар сургуулийн сурагч Г.Эрдэнэбилэгт Олон улсын тэмцээний зардалд 600.0 мянган төгрөг дэмжлэг үзүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 06-ны 43 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4 дүгээр зүйлийн 4.6-д “ОНХС-гийн хөрөнгийг буцалтгүй тусламж, дэмжлэгэд зарцуулахгүй байх” гэснийг зөрчсөн тул төлбөрийн акт бичлээ.
- Мэдээллийн ил тод байдал дэд хөтөлбөрийн хүрээнд нийт 12,360.0 мянган төгрөг зарцуулсан бөгөөд үүнээс “Сүмбэр дэлгэрэх билэг” ХХК-д мессеж үйлчилгээний нэгжний үнэнд 500.0 мянга, “Шинэ Чойр” телевизэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Чойрын толь” ТББ-тай гэрээ байгуулан 3,000.0 мянга, мөн “Чойрын толь” сонинд 1,260.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. “Шинэ Чойр” телевизэд шилжүүлсэн 3,000.0 мянган төгрөгийн тайланг 2015 оны 03 дугаар сарын 15-ны өдөр өгсөн бөгөөд дээрх нэгжний зарцуулалтын тайлан болон сонинг хэдэн хүнд тараасан талаарх баримт, тайлан байхгүй байна. Иймд “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4 дүгээр зүйлийн

4.4-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх”, 4.5-д “Орон нутгийн төсвийн бус байгууллагуудад ОНХС-гаас хөрөнгө зарцуулахгүй байх” 4.6-д “ОНХС-гийн хөрөнгийг буцалтгүй тусламж, дэмжлэгэд зарцуулахгүй байх” гэснийг тус тус зөрчсөн тул төлүүлэхээр төлбөрийн акт бичив.

- Сумын хогны менежментийг сайжруулахад 12 ажил төлөвлөснөөс хог шахдаг 100.000.0 мянган төгрөгний төсөв өртөгтөй автомашиныг худалдан авахаар тендер зарлан худалдан авах гэрээг 147,000.0 мянган төгрөгөөр хийж, төсөвт өртгөөс илүү үнээр худалдан авсан ба зөрүү 47,000.0 мянган төгрөгийг 2015 онд олгохоор гэрээнд тусгасан нь сумын ИТХ-ын тогтоолыг зөрчиж, батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн гэрээ байгуулсан тул үнийн зөрүүг олгохгүй байх тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.
- Харин хоёрдогч түүхий эдийн контейнэр худалдан авч хогийн цэгийн хажууд 2014 оны 10 дугаар сарын 20-30-ны хооронд байрлуулахаар “Алтан Ялтас” ХХК-тай 5,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан бөгөөд тус компани гэрээний хугацаанд 20 тн-ын контейнэрыг заасан газарт байрлуулан хүлээлгэн өгсөн боловч одоог хүртэл гэрээний дагуу олгох санхүүжилтийг олгоогүй байгаа нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж төрийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөхөд хүргэж байна.
- Иргэний танхимд 87,300.0 мянган төгрөгийн Toyota land Cruiser PRADO petrol маркийн автомашин худалдан авсан боловч нэмэлт гэрээ байгуулан 5 ширхэг өвлийн дугуй 1,700.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь төсөвт өртгийг хэтрүүлсэн, мөн “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4 дүгээр зүйлийн 4.4-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх” гэснийг зөрчсөн тул төлүүлэхээр төлбөрийн акт бичлээ.

3. Шивээговь сумын орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад илэрсэн зөрчил:

- Ясли цэцэрлэгийн байрын сантехникийн засварын ажил нэрээр 7,523.8 мянган төгрөг батлуулж авсан боловч уг мөнгөөр сумын ЗДТГ-ын сантехникийн засвар хийж хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Сургуулийн биеийн тамирын заалны шалыг резинэн хучилттай болгож гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх 13,993.8 мянган төгрөгийн ажлын гүйцэтгэлийг газар дээр нь очиж шалгахад уг гэрээнд заагдсан техникийн нөхцлийг зөрчиж, резинэн шал биш зориулалтын будгаар 7 удаа давхарлаж будсан байна. Иймд уг ажлыг гэрээний дагуу гүйцэтгэгдээгүй, чанаргүй хийгдсэн

тул гэрээнд заагдсан техникийн нөхцлийн дагуу гүйцэтгүүлэхээр албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

- 10,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтөй “Гудамж” хөтөлбөрийн хүрээнд сумын бүх хашаа, хашааны хаалга будаж, гудамж, хаалганы хаягыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч сумын ихэнх хашааг модон хашаа биш гэсэн нэрийдлээр будаагүй байгаа бөгөөд уг хөтөлбөрийг чанаргүй, дутуу гүйцэтгэсэн гэж үзэх үндэслэлтэй байна.

4. Баянтал сумын орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад илэрсэн зөрчил:

- Төмөр зам, авто зам огтлолцсон уулзварыг камержуулах 10,000.0 мянган төгрөгийн ажлыг “Ургах нар чойр” ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулж, ажлын санхүүжилтыг бүрэн авсан байна. Уг ажлыг газар дээр нь очиж шалгахад камер суурилуулах ажлыг гэрээний дагуу гүйцэтгээгүй, камерууд байгаа эсэх нь тодорхойгүй байсан. Аудитын явцад уг зөрчлийн талаар санал авахад гүйцэтгэгч байгууллагаас камеруудыг бүрэн авсан байгаа тул 2015 оны 6 сарын 25 гэхэд дахин угсарч бэлэн болгох тухай тайлбар, хүсэлтийг ирүүлсэн болно. Иймд гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу дурдсан хугацаанд бүрэн хийж гүйцэтгүүлэх нэмэлт гэрээ байгуулан ажлыг чанартай гүйцэтгүүлж, хүлээж авч данс бүртгэлд тусгах албан шаардлагыг өгөхөөр шийдвэрлэв.
- Төмөр замын 621, 14. 16. 18-р дугаар зөрлөгүүдэд иргэдийн бүлгэмүүдийн гүйцэтгэсэн тохижилт, явган хүний зам, тоглоомын талбай, ногоон байгууламж бий болгох тус бүр 20,000.0 мянга нийт 80,000.0 мянган төгрөгийн ажлын гүйцэтэлийг шалгахад тоглоомууд эвдэрсэн байсан тул засаж хэвийн болгуулахаар албан шаардлагыг өгөхөөр шийдвэрлэв.
- Сумын Залуучуудын талбайн усан оргилуурын 20.000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтөй засварын ажлыг “БҮҮК” ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулан хийж гүйцэтгэсэн байна. Уг ажлыг газар дээр нь очиж шалгахад гэрээнд заасан техникийн нөхцөлийг зөрчиж, усан оргилуурт зориулалтын зориулалтын бус плита нааснаас хагарч эвдэрсэн байна. Иймд гэрээнд заасан баталгааны хугацаанд нь дахин зориулалтын материалаар чанартай гүйцэтгүүлэн хүлээн авч, холбогдох данс бүртгэл тусгах талаар хугацаатай албан шаардлага өгөв.
- Байрнуудын өмнөх гэрэлтүүлэгийн 0.4-ын шугам татах 20,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтөй ажлыг “Баянтогод” ХХК гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж 26 гэрэл хийхээс 24 гэрэл хийж 2 гэрэл дутуу хийсэн

байна. Иймд дутуу 2 гэрлийг хийлгүүлэхээр хугацаатай албан шаардлага өглөө.

- Сумын 12 жилийн дунд сургуульд бөхийн дэвжээ худалдан авах 13,770.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтөй ажлыг “Бодог” ХХК гүйцэтгэхдээ гэрээний техникийн нөхцөлд заасан зориулалтын бөхийн дэвжээг хийж нийлүүлээгүй ба 2 ширхэг хивс худалдан авч хүлээлгэн өгсөн байна. Иймд зориулалтын бөхийн дэвжээг хийлгүүлж авах албан шаардлага өгч байна.
- Иргэний танхимын мэдээлэл сурталчилгааны ажлын зардал нэрээр 500.0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал гаргаж, ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Сумын өвс тэжээлийн нөөцийг жил бүр ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэдэг ба өмнөх жилүүдийн нөөцийн өвс зарцуулагдаагүй хуучирч, чанаргүй болж, ашиглалтын шаардлага хангахгүйд хүрч байгаа ба эдгээр өвс тэжээлийг зарж борлуулан нөхөн сэргээх арга хэмжээ авч ажиллаагүй байна. Иймд өмнөх жилүүдийн нөөцийн өвсийг худалдан борлуулж, уг зардлаар шинээр нөөцийн өвс бэлтгэж байх талаар зөвлөмж өгөв.

2.5. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.

Аймгийн төвийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 27 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Нээлттэй тендер шалгаруулалтаар 9, харьцуулалтын аргаар 7 төсөл арга хэмжээний ажлыг шалгаруулж, үлдсэн 11 ажлыг худалдан авах ажиллагааны нээлттэй болон харьцуулалтын аргаар шалгаруулсан тендерийн шаардлагад нийцсэн гүйцэтгэгч шалгараагүй шалтгаанаар хэлэлцэл хийх замаар гүйцэтгэгчийн шалгаруулж шууд гэрээг байгуулсан байна.

Сүмбэр суманд: сумын 2 дугаар цэцэрлэгийн гадна хашаа, тохижилт, автомашины зогсоол хийх ажлын үнэлгээний хороог Сүмбэр сумын Засаг даргын 2014 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/90 дүгээр захирамжаар байгуулсан бөгөөд үнэлгээний хорооны даргаар аймгийн ЗДТГ-ын дарга Б.Батдэлгэрийг томилсон нь хуулийн шаардлагад нийцээгүй байна.

Мөн дээрх ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад “БЭМЭС” ХХК, “Чойсамбуу” ХХК гэсэн 2 компани тендерт оролцох материалаа ирүүлсэн боловч дээрх 2 компанийн ирүүлсэн баримт материал

тендерийн ерөнхий шаардлагыг бүрэн хангаагүй, зарим материалаа дутуу ирүүлсэн тул тус сумын хөрөнгө оруулалтын мэргэжилтэн болон бусад гишүүд дээрх 2 компанийг шаардлага хангахгүй гэж үзэн татгалзсан дүгнэлт гаргасан байхад үнэлгээний хороо “Чойсамбуу” ХХК-ийг хамгийн сайн тендерээр шалгаруулж гэрээ байгуулахыг зөвлөснөөр ТБОНӨХБАҮХАТХ-ийн 47.8 дахь заалтыг зөрчиж, тендерийн шаардлага хангаагүй “Чойсамбуу” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Шивээговь суманд: ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний Үнэлгээний хороо, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөл, худалдан авах ажиллагаанд мэргэшсэн А-3 сертификаттай ажилтнуудыг оруулаагүй байна.

Баянтал суманд: ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог Сумын Засаг даргын тушаалаар байгуулаагүй, зөвхөн ажлын хэсэг байгуулж ажилласан нь 2012 оны 194 дүгээр тушаалаар батлагдсан “Олон нийтийн худалдан авах ажиллагааны журам” 2 дугаар зүйлийн 2.1-д “Сум дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах 20 сая хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотой сонгон шалгаруулахдаа захиалагч нь хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хороо байгуулна” гэж заасныг зөрчсөн.

Мөн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын хэсэгт хөрөнгө оруулалтын мэргэжилтэн, төрийн сангийн төлөөлөгч В.Гантуяаг оролцуулсан нь өөрийн хариуцсан ажил үүргийн дагуу шууд хяналт тавьдаг ажлыг давхар гүйцэтгэж, “Нийтийн албанд нийтийн хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийг зөрчсөн байна.

2.6. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн 502,496.6 мянган төгрөгийн хөрөнгийг данс, бүртгэлд дутуу тусгасан байна.

Аймгийн ИТХТ-ийн 2014.12.22-ны өдрийн 51-р тогтоолын 1-р хавсралтаар Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хүрээнд бэлтгэгдсэн 83 нэр төрлийн 4.388,405,9 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудын данс бүртгэлд тусгуулсан байна. Гэтэл аймгийн ИТХ-ын хурлаас 2014 онд дуусаагүй 14 ажлын 505,781.2 мянган төгрөгийн хөрөнгийг дуусаагүй барилга дансанд бүртгэх тогтоол гаргасан боловч санхүүгийн

тайланд олгосон санхүүжилтээр бүртгэж 74,311.9 мянган төгрөгийн хөрөнгийг дутуу бүртгэсэн байна.

Мөн Шивээговь сум 9 ажлын 164,852.1 мянга, Баянтал сум 12 ажлын 263,332.6 мянга, нийт 428,184.7 мянган төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгаагүй байна. Иймд уг хөрөнгийг хүлээн авсан анхан шатны баримт материал, ажлын хэсгийн актыг үндэслэн холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгуулахаар хугацаатай албан шаардлага өгөв.

Бүлэг 3

ОНХС-гийн хөрөнгийг зарцуулалтанд тавих шат шатны
хяналтыг хангалттай зохион байгуулж ажиллаагүй
байна.

3.1. ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийг иргэдэд ил тод мэдээлж ажиллаагүйгээс, сумдын иргэдийн оролцоо идэвх сул байна.

Аймгийн ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалт, хэрэгжилтийн талаар иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээлэл сурталчилгаа хийж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гарган иргэдэд тарааж, тендер болон А-3 сертификатын сургалтыг зохион байгуулж, 2013-2014 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын талаар 10 гаруй танилцуулга, ажлын тайлан зэрэг материалыг гаргаж иргэдэд тараасан байна.

Гэвч багийн иргэдийн идэвхи сул, хурлын зар хүргэх ажил хангалтгүй, зохион байгуулагдсан зэргээс шалтгаалан ОНХС-гийн хөрөнгөөр хийх ажлын санал авах хурлын ирц хангалттай бүрдээгүй байна. Энэ нь ОНХС-гийн зарцуулалтанд тавих иргэдийн хяналтыг сайжруулах, оролцоог нэмэгдүүлэх, багийн иргэдийг идэвхи санаачлагыг дээшлүүлэх талаар сургалт, сурталчилгааг хангалттай зохион байгуулаагүйтэй холбоотой бөгөөд энэ нь ч ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний талаар иргэдээс авсан санал асуулгад өгсөн хариултаас харагдаж байна.

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга, хэмжээний хэрэгжилтэд аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас хяналт тавьж ажилласан байна.

2014 онд аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гэрээний биелэлтэнд аймгийн ХБХ-ээс захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж, 5 ажлын 9,266.3 мянган төгрөг, мөн замын техник хяналтын зардлаас 16,677.3 мянга, нийт 25,943.6 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан байна.

3.3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хууль, журмын дагуу хүлээж авсан байна.

2014 онд Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл арга хэмжээний ажлаас дор дурдсан ажлууд хугацаандаа хэрэгжээгүй, нэмэлт гэрээгээр хугацааг нь сунгасан байна. Үүнд:

- Соёл амралтын хүрээлэнгийн Хөлбөмбөг болон Кокейн талбайн ажлыг “Самосон” ХХК 2014.08.30-нд хийж дуусгахаар гэрээ байгуулж ажилласан боловч ажил гүйцэтгэх явцад нь гүйцэтгэгчээс үл шалтгаалсан нэмэлт ажлууд гарсан, цаг агаарын байдал эрт хүйтэрсэн зэргээс шалтгаалан 2014.10.31-нд МХГ-ын албан шаардлага, ГХБХБГ-ын мэдэгдлийг үндэслэн ажлыг нь түр зогсоох акт үйлдэн 2015 оны 7 сард уг ажлыг гүйцэтгэн хүлээлгэж өгөхөөр гэрээг сунгасан байна.

Шивээговь суманд барих Цэнгэлдэх хүрээлэнгийн барилга угсралтын ажил тендер шалгаруулалтыг аймгийн тендерийн үнэлгээний хорооноос сонгон шалгаруулсан ба шалгаруулалт нь оройтож хийгдснээс ажлын гүйцэтгэл он дамжин хэрэгжихээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж хугацааг нь сунгасан байна.

Сүмбэр суманд ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосон бөгөөд зарим ажлын хувьд тухайн нөхцөл байдлаас шалтгаалан гэрээгээ сунгасан байгууллагууд хугацаандаа ажлаа хүлээлгэж өгсөн байна. Харин хугацаа хоцроосон 3 байгууллагад нийт 1,407.8 мянган төгрөгийн алданги тооцсон байна.

3.4. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг 50 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

2013 оны Аймгийн ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт үр дүнд хийсэн нийцлийн аудитаар өгсөн 4 зөвлөмжөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Үүнд: Иргэдээс санал аваагүй болон эрэмбэлэгдээгүй ажилд хөрөнгө батлуулсан, жилийн дундуур нэмэгдэж хийгдэж байгаа ажлуудад иргэдээс санал аваагүй, ИТХ-ын тогтоолын хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Сүмбэр сум: Өмнөх аудитаар дутуу хийгдсэн ажлыг нь гэрээний дагуу дахин хийлгэх, гэрээнд заасны дагуу ажлыг эхлүүлэх болон хугацаа сунгасан ажлыг дуусгах тухай нийт 12 ажилд албан шаардлага өгсний 9 ажлыг бүрэн хэрэгжүүлж ажлын хэсэг болон улсын комисс хүлээн авсан байна. 3 ажил огт хийгдээгүй байна.

Харин “Классик тохижилт” ХХК, “ЗМЗ” ХХК, “Элит харш” ХХК гэсэн 3 компаниуд ажлаа бүрэн дуусгаж хүлээлгэж өгөөгүй учир шүүхэд шилжүүлсэн бөгөөд шүүхийн шатанд явж байна.

Шивээговь сум: өмнөх аудитаар 4 зөвлөмж өгснийг 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.Үүнд:

1. Иргэдээс авсан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлын орон нутгийн иргэдийн саналыг эрэмбэлсэн ажлын жагсаалт холбогдох шийдвэрүүдийг нэгтгэсэн тайлан гаргаж архивласан боловч 1 болон 2-р багийн саналууд нэгтгэсэн жагсаалт баримтаар байхгүй байсан.
2. Хөрөнгө оруулалтын мэргэжилтний ажлын байрыг зарласан боловч нэг ч хүн тэнцээгүй бөгөөд ажлын байрны захиалгыг дахин өгсөн байна.

Баянтал сум: өмнөх аудитаар 4 зөвлөмж өгснийг 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бөгөөд 1,400.0 мянган төгрөгийн акт, нийт 662,900.0 мянган төгрөгийн албан шаардлага өгснөөс 336,400.0 мянган төгрөгийн албан шаардлагын биелэлтийг хангаагүй байна. Акт, албан шаардлагыг хэрэгжүүлж биелэлтийг нь гаргаж ирүүлэх талаар удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй ба ирүүлэхээс зайлсхийсэн болно. Тиймээс холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож, Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд” үүрэгт ажлаас нь халах тухай саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ гэсний дагуу ажлаас чөлөөлөх саналыг холбогдох дээд байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэсэн болно.

3.5. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн болон сумд нь ОНХС-ийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын талаар Shilendans.gov.mn вэб сайтад төрийн сангаас шилэн дансны эрхээ авч, 2015 оны ОНХС-гийн эрх бүхий байгууллагаас батлагдсан жилийн төсөв, гүйцэтгэл зэрэг мэдээллийг байгууллагын шилэн данс цэсэнд байршуулж нэгдсэн шилэн данс хаягтай холбосон байна. Бусад тендер, сонгон шалгаруулалттай холбоотой баримтуудыг байршуулаагүй байгаа нь худалдан авалтын ил тод байдлыг хангаж ажиллахгүй байна гэж үзэх үндэслэлтэй байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

- 2014 онд ОНХСанд 2013 оны үндсэн тэнцлийн ашиг 689,222.7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 33,833.7 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн, мөн сумдад улсын төсвөөс ноосны урамшуулалд олгосон 6,448.5 мянга, Сүмбэр сум халамжийн сангийн үлдэгдэл 62,362.0 мянга, нийт 68,810.5 мянган төгрөгийн орлогыг аймгийн ОНХС-д төвлөрүүлэлгүйгээр сумын ОНХС-даа шууд төвлөрүүлэн, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийг зөрчсөн байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй 33 төсөл арга хэмжээ буюу 802,380.6 мянган төгрөгийн ажлыг санхүүжүүлсэн байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг ИТХ-аас батлахдаа төсөл, арга хэмжээний нэг бүрчилсэн жагсаалт гаргалгүйгээр бөөн дүнгээр буюу багцаар баталсан байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байна.
- ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналт хангалтгүй байгаагаас хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж 684,122.2 мянган төгрөгийг, төсөвт өртгөөс 48,700.0 мянган төгрөгөөр илүү дүнгээр ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан, үйл ажиллагааны зардалд 10,433.8 мянган төгрөгийг тус тус зарцуулж, нийт 743,256.0 мянган төгрөгийн зөрчил дутагдал гаргасан байна.
- ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бэлтгэсэн 502,496.6 мянган төгрөгийн хөрөнгийг данс, бүртгэлд дутуу тусгасан байна.
- Өмнөх оны аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар өгсөн зөвлөмжийн 50 хувийг хэрэгжүүлэн ажиллаагүй ба давтан гаргасан байна.
- Уг аудитаар нийт 2,362,021.7 мянган төгрөгийн 104 зөрчил дутагдал илрүүлсэн ба 8,085.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 735,560.4 мянган төгрөгийн албан шаардлага, 1,207,815.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмж

өгч, зарим холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлэхээр тус тус төлөвлөөд байна.

- Дээрх зөрчил дутагдлаас харахад ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт маш хангалтгүй байгаа ба орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагын хөндлөнгийн хяналт хангалтгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Нэг. Аймгийн Төрийн сангийн хэлтсийн дарга Н.Одонтуяа, Хөгжлийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч М. Анхбаяр нарт:

- 2013 оны үндсэн тэнцлийн ашгаас дутуу төвлөрүүлсэн 33,833.7 мянган төгрөгийг ОНХС-д төвлөрүүлэх;
- Аймгийн ОНХС-д төвлөрүүлэх орлогыг сумын ОНХС-д шууд төвлөрүүлэн зарцуулж байгаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх;
- Орон нутгийн иргэдийн санал болон ИНХ-аар дэмжигдээгүй, иргэдийн саналаар дэмжигдсэн хэдий ч иргэдийн саналыг эрэмбэлсэн жагсаалтаа ирүүлээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, ИТХ-аар батлуулахгүй байх;
- ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний жагсаалтыг багцаар биш нэг бүрчлэн гаргаж аймгийн ИХТ-аар батлуулж байх;
- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг хуулийн дагуу зохион байгуулах;
- Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хуулийн дагуу бүрдүүлж, сонгон шалгаруулалтын ажилд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах;
- ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулах, үйл ажиллагааны зардал, төлөвлөгдөөгүй хөрөнгө бэлтгэх зэргээр зориулалт бусаар зарцуулахгүй байх;
- ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бэлтгэгдсэн хөрөнгийг хүлээж авсан акт, баримтыг үндэслэн холбогдох байгууллагын данс бүртгэлд бүрэн бүртгэж, тайлагнаж байх;
- Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тодорхой ажил зохион байгуулж, биелэлтийг гаргаж хугацаанд ирүүлж байх.

Хоёр. Сумдын Засаг дарга нарт:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх орлогыг сумын ОНХС-д шууд төвлөрүүлэн зарцуулж байгаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх

2. Орон нутгийн иргэдийн санал болон ИНХ-аар дэмжигдээгүй, иргэдийн саналаар дэмжигдсэн хэдий ч иргэдийн саналыг эрэмбэлсэн жагсаалтаа ирүүлээгүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, ИТХ-аар батлуулахгүй байх;
3. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний жагсаалтыг багцаар биш нэг бүрчлэн гаргаж аймгийн ИХТ-аар батлуулж байх;
4. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг хуулийн дагуу зохион байгуулах;
5. Тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хуулийн дагуу бүрдүүлж, сонгон шалгаруулалтын ажилд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах;
6. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтыг батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулах, үйл ажиллагааны зардал, төлөвлөгдөөгүй хөрөнгө бэлтгэх зэргээр зориулалт бусаар зарцуулахгүй байх;
7. Аймаг, сумын Улсын баяр наадмын зардлыг Засгийн газрын 2010 оны 271 тоот тушаалаар баталсан дээд хязгаарт багтаан зарцуулж байх;
8. Сумын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэхдээ өмнөх жилүүдэд авсан зарцуулагдаагүй, чанарын шаардлага хангахгүй болсон өвс тэжээлийг сумын ИТХ-аар үнийг нь тогтоолгон зарж, орлогыг нь нөхөн сэргээх, шинээр худалдан авахад нь зарцуулж байх арга хэмжээ авч ажиллах;
9. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бэлтгэгдсэн хөрөнгийг хүлээж авсан акт, баримтыг үндэслэн хүлээн авч холбогдох байгууллагын данс бүртгэлд бүрэн бүртгэж, тайлагнаж байх;
10. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар тодорхой ажил зохион байгуулж, биелэлтийг гаргаж хугацаанд ирүүлж байх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

	АУДИТЫН ГАЗАРТ
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР	
42017 Чойр, Говьсүмбэр аймаг, Утас: 7054-3118, E-mail: GSAimag@yahoo.com	
2015.05.05 № 09/550 талай 2015.05.05 -ны № 08 -т	
Тайлбар хүргүүлэх тухай	
Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Аудитын ерөнхий газрын баталсан удирдамжийн дагуу танай байгууллагаас манай аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн. Тус шалгалтын мөрөөр танайхаас ирүүлсэн шалгалтын тэмдэглэлийн 5-д Орон нутгийн хөгжлийн сангаар хийгдсэн ажлын шалгалтаар илэрсэн зөрчил болон дүгнэлттэй танилцахад бидний тайлбарыг бүрэн тусгаагүй дүгнэлт гаргасан байсан тул дүгнэлтийг үл зөвшөөрөн дараах тайлбарыг хүргүүлж байна. 1. Иргэдийн санал аваагүй 491 430 000 төгрөгийн ажил төлөвлөсөн байна гэсэн нь: - Сангийн сайдын 2014 оны 43 дугаар "Заавар батлах тухай" тушаалын 6 дүгээр зүйлд "Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөх" зааврыг баталсан байгаа бөгөөд зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг тухайн аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт туссан үйл ажиллагаа, урьд оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг харгалзан боловсруулна.", 6.4-т "Урьдчилсан саналын жагсаалтыг аймаг, нийслэлийн дэргэдэх Иргэний танхимаар нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулна." гэж заасны дагуу 2014 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сан болон 2014 оны төсвийн тодотголын саналыг хуулийн дагуу зохион байгуулсан. - 2014 оны Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг саналыг төлөвлөхдөө аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон бусад бодлогын бичиг баримтыг үндэслэн 7 багц асуудлын хүрээнд санал авсан бөгөөд Иргэний танхимын засварын ажилд 25,0 сая төгрөг, Иргэдэд үйлчлэх төвийг засварлахад 20,0 сая төгрөг зарцуулсан нь багц асуудлуудын 6 дахь санал буюу мэдээ мэдээллийн ил тод байдлын хүрээнд төлөвлөн хэрэгжүүлсэн ба Иргэний танхимын үйл ажиллагааг сайжруулах. Иргэдэд үйлчлэх төв бий болгох асуудлууд нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын бодлого чиглэлийн хүрээнд туссан ажлууд юм. Харин шинээр үүсч буй 40 айлын орон сууцны хорооллын гадна шугамын ажилд 21 сая төгрөг зарцуулсан нь багц асуудлын 2-т "Инженерийн дэд бүтцийг сайжруулах" гэсэн саналын хүрээнд төлөвлөсөн ба 2013 оны ОНХС-аар гадна цахилгааны ажил хийгдсэн тул журмын дагуу дараа оны ОНХС-анд өмнөх оны ОНХС-аар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг харгалзан үзэж төлөвлөн хэрэгжүүлсэн болно. Иймд дээрх ажлууд нь иргэдээс санал авч эрэмблэгдэн	

03 0124

боловсруулсан төслөө хамгийн сүүлийн байдлаар ИТХ-д өргөн барихаас өмнө иргэдээр хэлэлцүүлсэн тул иргэдээс санал авсан байна.

- Монгол Улсын 2014 оны төсөвт тодотгол саналыг боловсруулан 2014 оны 6 сарын 23-оос эхлэн Аймгийн холбооны газрын ТВ болон Шинэ чойр ТВ, цаасаар зар наах зэргээс сурталчилан 2014 оны 6 дугаар сарын 25-ны өдөр аймгийн Иргэний танхимд хэлэлцүүлэх байсан боловч 4 хүн ирсэн тул цаасаар саналыг нь авч буцаасан. Энэ сурталчилгаа амжилтгүй болсон тул аймгийн Засаг даргын Тамгын газраас утасны нэгж гаргуулан Сүмбэрийн мессеж программаар 500 иргэдэд мессеж зарыг явуулан 2014 оны 6 дугаар сарын 27-ны 13 цагт болгон хойшлуулсан боловч мөн хүн ирээгүй. Иймээс дахин 700 хүнд мессеж зар хүргүүлэн 2014 оны 6 дугаар сарын 27-ны 14.30 болгон хойшлуулаад ч ирээгүй. Иймд ИТХ-д өргөн барих хугацаа түлж цаг хугацаа байхгүй байсан тул 17 цагаас 22 иргэнийг цуглуулан Иргэний танхимд 18.20 минутанд хурлаа эхлүүлсэн. Түүнчлэн амралтын өдрөөр сумдын багийн хурлуудаас санал авч 28 хүнээс цаасаар санал авсан ба давхар www.govisumber.gov.mn сайтаар санал авч иргэдээр хэлэлцүүлсэн болно.

2. 2014 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Засаг даргын Тамгын газарт 145,0 сая төгрөгийн автомашин худалдан авсан нь:

- Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.3-т "Аймаг өөрийн төсвөөр аймгийн удирдлагыг хэрэгжүүлэх, орон нутгийн өмчийн барилга, байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ" гэж заасан ба иргэдээс санал авсны үндсэн дээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тогтоолын дагуу дээрх ажлуудыг хэрэгжүүлсэн. Аймгийн Засаг даргын албан хэрэглээндээ хэрэглэж байсан машин нь нэг удаа онхолдож, нэг удаа шатаж, ашиглалтын зардал их, жил бүр олон сая төгрөгийн засвар үйлчилгээ хийлгэдэг автомашин байсан. Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолд Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, аймаг нийслэлийн Засаг дарга нь албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий өндөр дээд албан тушаалтан байна гэж заасан. Түүнээс гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас ирүүлсэн хамтран ажиллах саналд Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 25.4, 25.5 дахь заалтуудыг биелүүлэх, шүүхийн шийдвэр биелэгдэхгүй хүүхдийн эрх ашиг зөрчигдсөөр байгааг таслан зогсоох зорилгоор аймгийн Засаг даргаас Тахарын албанд автомашин шийдвэрлэж өгөх хүссэн тул аймгийн Засаг даргын орлогч даргын Ланд крузер 80 маркын автомашиныг шилжүүлэн өгсөн ба төрийн албыг хүндрэлгүй, шуурхай явуулах үүднээс аймгийн Засаг даргын Тамгын газарт автомашин шаардлагатай болсон. Иймд иргэдээр хэлэлцүүлж санал авсны үндсэн дээр ойрын 10 жилд эвдрэл гарахгүй, төсөвт хүндрэл учруулахааргүй шинэ машин авахаар төлөвлөн хэрэгжүүлсэн нь төсвийн хөрөнгийг хэмнэсэн гэж үзэж байна.

- 2014 оны аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаар Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэст тоног төхөөрөмж худалдан авч өгсөн нь:

- Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17-д "Аймаг өөрийн төсвөөр хуульд заасан бусад чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ" гэж заасан ба Цагдаагийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нь нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор тодорхой нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба хаагчийг орон байр, хүнс, тээвэр, холбооны хэрэгслээр хангах, томилогдсон алба хаагч, түүний гэр бүлийн гишүүдэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж болно" гэж заасныг үндэслэн Цагдаагийн хэлтэст тээврийн

хэрэгсэл-1 ширхэг, хурд хэмжигч-1 ширхэг, согтуурал хэмжигч-4 ширхэг тоног төхөөрөмж худалдан авч өгснөөр дуудлагад хурдан шуурхай үйлчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, хурд хэтрүүлэх зэрэг Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 22.7 хувиар буурсан.

- Монгол Улсын Шадар сайдын 2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн ЗГ-2/194 тоот албан даалгаврыг үндэслэн Онцгой байдлын хэлтсийн ашиглалтын хугацаа дуусч, үүргээ биелүүлэх боломжгүй болсон гал унтраах, аврах зориулалтын автомашиныг орчин үеийн загварын ОХУ-д 2014 онд үйлдвэрлэсэн тусгай зориулалтын автомашинаар солиж 197,5 сая төгрөг зарцуулсан нь Онцгой байдлын хэлтсийн үйл ажиллагаа, гэнэтийн осол аваар, гал түймрийн үед техникийн сааталгүй, хурдан шуурхай арга хэмжээ авч ажиллах боломжийг олгож ард иргэдийн амар тайван амьдралыг сахин хамгаалах төрийн чиг үүргээ биелүүлсэн. Шинэ автомашинтай болсноор Онцгой байдлын хэлтсийн шатахууны зардлыг хэмнэж төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулсан юм.

- Төсвийн тухай хуулийн 58.2.5, 58.2.6-д орон нутаг өөрийн төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт "Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх", "Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх" гэж заасныг үндэслэн газар тариалангийн техник үйлчилгээний цэг байгуулагдаж байгаа ажлын хүрээнд дунд оврын трактор худалдан авч өгснөөр газар тариалан эрхлэгчдийн дэмжин, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэн ургацын хэмжээг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн байна.

- Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17-д "Аймаг өөрийн төсвөөр хуульд заасан бусад чиг үүргийг бие даан хэрэгжүүлнэ" гэж заасан ба Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7.5-д "Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дах салбар, нэгж ажилтны бүртгэлийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга дэмжлэг үзүүлнэ" 16.1-д "Бүх шатны төрийн байгууллага улсын бүртгэлийн үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах хуульд заасны дагуу хамтран ажиллах үүрэгтэй", мөн Хууль зүйн сайд болон аймгийн Засаг даргын гэрээнд зааны дагуу хуулийн этгээдийн мэдээллийг цахимжуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангасан. Энэ ажил нь иргэд ААНБ-д үйлчлэх үйлчилгээг цахимжуулан сайжруулж ТҮЦ машин, интернетээр лавлагаа мэдээлэл авах, УБГ-аас мэдээллийг шуурхай гаргуулах боломж нөхцлийг бүрдүүлж байгаа. Түүнээс гадна Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирсэн хүсэлтийн дагуу энэхүү тоног төхөөрөмжийг төлөвлөсөн байна.

3. 2013 оны дуусаагүй барилгын ажлын хувьд:

- Хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний төв зогсоол байгуулах ажлыг 2013 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр гэрээ байгуулж 2013.10.05-ны өдөр дуусгахаар төлөвлөж гэрээ байгуулсан. Цаг агаарын байдал болон санхүүжилтын удаашрал, материалын эрэлт их байгаагаас олдоц муу зэргээс ажил удааширсаар 2013 оны 11 сарын 10-нд хүйтэрсний улмаас ажил зогсоох акт үйлдэж, 2014.04.10-ээс 2014.05.20 хүртэл гүйцэтгэхээр гэрээг сунгав. Гэвч Магнус солус ХХК цаг хугацаандаа ажлыг эхлүүлэлгүй холбоо, сураггүй алга болсон тул шүүхэд нэхэмжлэл гаргаж шүүхийн шийдвэрээр тахарын албаар хайлгахаар захирамж гарч хайлгаж байна.

4. Аймгийн ИТХ-ын тогтоолоос санхүүгийн тайланд дутуу тусгасан дуусаагүй барилга зөрсөн:

- Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолд байгууллагуудад өмч хуваарилсан тул дууссан ажлуудын гүйцэтгэлийн дүнгээр тусгасан. Харин санхүүгийн тайланд орон нутгийн хөгжлийн сан 2 тэрбум төгрөгний санхүүжилт ирээгүйгээс ажил нь дуусч хүлээн

авсан ажлуудын санхүүжилт нь дутуу олон ажлууд байгаа ба энэ дүнгээр санхүүгийн тайландаа тусгах ёстой учраас зөрх байгаа юм.

Түүнчлэн дээрх ажлууд нь Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ба хуулийн дагуу иргэдийн олонхийн саналаар дэмжигдэн хэрэгжүүлсэн болно.

Иймд дээрх тайлбарыг хүлээн авч зөрчилтэй дүгнэлт гаргасан шийдвэрээ дахин нягталж үзнэ үү.

Хавсралтаар холбогдох нотлох баримт буюу хуулийн заалтууд, албан тоотуудыг хүргүүлэв.

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.АНХБАЯР

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

Тайлбар 1: Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс нь ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөл арга хэмжээг 7 багц болгон иргэдээс санал авч хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг баталсан боловч 4 ажлын нэр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад ороогүй байсан.

Мөн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжүүлэх дарааллыг 7 бүлгээр эрэмбэлэсэн байснаас ажил тус бүрээр эрэмбэлээгүй байсан, Мөн төсвийн тодотголоор 9 ажлын 414,430.0 мянган төгрөгийг нэмж батлахдаа иргэдээс санал аваагүй, иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлэг хийхэд 22 иргэн ба тус ажлуудыг танилцуулж гар өргүүлж санал хурааж, төсвийг баталсан нь иргэдээс санал авсан, жагсаалтанд баталсан гэж үзэхэд хангалтгүй байгаа тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж хэвээр үлдээв.

Тайлбар 2: ОНХС-гийн хөрөнгөөр улсын төсвөөс санхүүждэг байгууллагуудад хөрөнгө бэлтгэж зориулалтын бус зүйлд зарцуулсан байна

Энэ нь Монгол улсын төсвийн тухай хуулийн 60.4-д энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй гэснийг зөрчсөн байна.

Мөн Монгол улсын Сангийн сайдын 2014.03.06-ны өдрийн 43-р “ Заавар батлах тухай” тушаалаар баталсан “ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээг төлөвлөхөд баримтлах зарчим”-ын 4-р зүйлийн 4.4-д “Аймаг нийслэл, сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх”, 4.6-д ОНХС-гийн хөрөнгийг буцалтгүй тусламж, дэмжлэгд зарцуулахгүй байх” гэсэн зарчмыг баримтлаагүй, Мөн зааврын 7-р зүйлийн 7.2-т “аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргүүдийг 7.2.1-7.2.12 заасан тул дээрх тайлбарт заасан заалтууд нь хамаарахгүй байгаа тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

Тайлбар 4: ОНХС-гийн тайланд ИТХ-ын гаргасан тогтоолоос дуусаагүй барилга 121,225.6 мянган төгрөгийг дутуу бүртгэсэн нь өмнөх онд дуусаагүй барилгаар бүртгэсэн 2 ажлын 69,000.0 мянган төгрөгөнд нөхөж тогтоол гаргасан, 2014 онд хийсэн 1 ажлын 1,500.0 мянган төгрөгөнд тогтоол гаргаагүй байна.

Мөн ОНХС-гийн тайланд 2014 онд өглөг, авлага тусгаагүйтэй холбоотой дуусаагүй барилгыг олгосон санхүүжилтээр бүртгэж тогтоолоос 8 ажлын 73,861.9 мянган төгрөгийг дутуу, 1 ажлын 450.0 мянган төгрөгийг дутуу, 1 ажлын 20,586.3 мянган төгрөгөөн ажлыг тогтоолгүй бүртгэсэн байна. Иймд тогтоолоос дутуу бүртгэсэн 74,311.9 мянган төгрөгийг бүртгүүлэхээр тайланд өөрчлөлт оруулав.